

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

2020.06.02

Цагаандэлгэр сум

Заалтын дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын дугаар	Хариуцах байгууллага	Хэрэгжилт бичих чиглэл	Үнэлгээ
ЗГ-ын тогтоол					
14	Төрийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 2019-04-17 Дугаар 2019_149	1.. Улаанбаатар хот болон орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа “Нэг цонхны үйлчилгээ”, “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийг 2019 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн операторын хэлбэрээр үйлчилгээ үзүүлдэг “Үйлчилгээний нэгдсэн төв” болгон өөрчлөн зохион байгуулах, бүх сумдад “Үйлчилгээний нэгдсэн төв” байгуулж иргэн, хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	ТЗУХ Сумдын ЗДТГ	Сумын ЗДТГ-ын нэг цонхны үйлчилгээгээр давхардсан тоогоор 1147 иргэн, 768 өрх, 30 гаруй хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг хүргэсэн байна. Нийгмийн даатгалын үйлчилгээний хүрээнд ажилгүйдлийн даатгалын сангаас 14 иргэнд, тэтгэврийн даатгалын сан нэмэлтээр 6 иргэнд 2260440 төгрөг олгосон. Шинээр 5 иргэн тэтгэвэр тогтоолгосон. Тэтгэмжийн даатгалын сангаас 12 иргэнд үйлчилж хөдөлмөрийн чадвар түр алдалтын тэтгэмж, жирэмсэн амаржсаны тэтгэмжинд 5580853 төгрөгийг олгосон байна. Эрүүл мэндийн даатгалд 87 хүн хамрагдаж 3400000 төгрөг төвлөрүүлсэн байна. Сайн дурын даатгуулагч 300 орчим иргэнд үйлчлүүлж зөвлөгөө мэдээлэл авсан байна Улсын бүртгэлийн үйлчилгээнд 69 хүн хамрагдсан. Иргэний үнэмлэх шинээр авах болон сунгалт хийлгэх захиалга өгсөн 15 иргэн, төрсний гэрчилгээг 9 хүүхдэд олгож, нас баралтын гэрчилгээ 4, эд хөрөнгийн эрхийн гэрчилгээг 10 иргэнд, иргэний үнэмлэх 21 иргэнд олгосон. Мөн улсын бүртгэлийн үйлчилгээний лавлагааг 10 олгосон байна. Сумын татварын алба нь 2019 оноос эхлэн иргэдэд үзүүлэх үйлчилгээгээ цахим болгосонтой холбоотойгоор үйлчилгээ авах иргэдийн тоо нэмэгдсэн байна. Тухайлбал: itax.mta.mn, цахим төлбөрийн системийн e-barimt аппликейшн, etax.mta.mn, мөн тээврийн хэрэгслийн нэгдсэн	100

			цахим үйлчилгээ smartcar.mn зэргийг ашиглан иргэд татвараа төлж байна. 2020 оны эхний 6 сарын байдлаар цахимаар болон ирж үйлчлүүлсэн иргэдээс хувь хүний орлогын албан татварт 122, цахим сайтыг ашиглан бусад татварт хамрагдсан 131 нийтдээ 253 иргэн татварын үйлчилгээнд хамрагдсан байна. Дээрх үйлчилгээ авсан иргэдийн ихэнх нь цахим үйлчилгээ буюу e-barimt.mn аппликейшн, itax.mta.mn зэргийг ашиглан авто татвар, ИОТатварыг төлсөн байна. Хөдөлмөр эрхлэлт, халамжийн үйлчилгээг Нийт 79 иргэнд иргэнд үйлчилгээ үзүүлсэн. Үүнд: • Хүүхдийн мөнгөтэй холбоотой 22 • Насны хишгийн мөнгөн тэтгэмжид хамрагдах 7 • Эмнэлэгийн хяналтанд байдаг байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны иргэний эм тарианы хөнгөлөлт 4 • Жирэмсэн эхийн тэтгэмж 9 • 0-3 насны хүүхдээ асарч байгаа эх 11 • Халамжийн тэтгэвэрт хамрагдах 2 • Ахмад настанд үзүүлэх рашаан сувилалын хөнгөлөлт 5 • Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлэхийг хүссэн 9 • Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан асрах 2 • Байнгын асаргаа шаардлагатай ХБХүүхэд асрах 2 • Хиймэл шүд хийлгэх хөнгөлөлт хүссэн 2 • Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн асрах 1 • Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах 3 Хөдөө аж ахуйн чиглэлээр 2019 онд арьс ширний урамшуулал авах хүсэлтээ өгөөд байсан 25 өрхөд 1277 хонины нэхий, 30 өрхөд 1155 ямааны арьс, 4	
--	--	--	--	--

				өрхөд 35 үхрийн шир, 3 өрхөд 57 адууны ширний урамшууллыг олгосон. 141 өрхийн 51551 кг хонины ноосонд, 3 өрхийн 310 кг тэмээний ноосонд, 317 малчин, мал бүхий иргэдэд 64566 ямааны ноолууранд тус тус урамшуулал бодогдон олгогдлоо. Бог малын хээлтүүлэгч бух ээмэглэхээр “Тэргүүн сүрэг трейд” ХХК –тай Хүнс хөдөө аж ахуйн газар гэрээ хийн ээмгийг зээлээр авсан ба төлбөрийн 85,9 хувийг тус компаны дансанд төвлөрүүлэн ажилласан. Нотариатын үйлчилгээнд 287 хүн хамрагдаж гэрээний үнэн зөвийг гэрчлэх үйлчилгээнд 31, итгэмжлэл 19, баримт бичгийн хуулбар 226, гарын үсгийн баталгааг 11 иргэнд гаргаж өгсөн байна. Архиваас малын А данс, цалингийн лавлагааг 14 иргэнд өгсөн байна. Мал эмнэлгийн үйлчилгээний хүрээнд 68 малчин өрхөөр орж Мал амьтны эрүүл мэндийн хуулийн талаарх гарын авлага тараасан. Малын гоц халдварт Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг 177 өрхийн үхэр 3245, хонь 72138, ямаа 61703 нийт 137086 малыг хамруулсан байна.	
15		3.. Иргэн, хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхэд төрийн мэдээллийн сангаас гарах боломжтой лавлагаа, мэдээллийг шаардахгүй байх зарчмыг баримтлан технологийн дэвшлийг ашиглаж төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системд хандан авах замаар шийдвэрлэх, “Үйлчилгээний нэгдсэн төв”-д ажиллах байгууллагын албан хаагчдын орон тооны дээд хязгаарыг батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэхийг холбогдох сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж, Шүүхийн ерөнхий зөвлөл (Н.Лүндэндорж)-д зөвлөсүгэй.	ТЗУХ Сумдын ЗДТГ	Эхний хагас жилийн байдлаар “Хур” системд 10 сая төгрөгний тоног төхөөрөмжөөр хангагдаад байна. Бүтэц орон тоог шийдвэрлээгүй байна.	70
16		9. “Үйлчилгээний нэгдсэн төв”-ийн ажилтнуудыг шаардлагатай сургалт, дадлагад хамруулах талаар зохих арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Нэг цонхны	ТЗУХ Сумдын ЗДТГ	2020 оны 5 сарын 27нд Аймгийн Засаг даргын Тамгын газар, Харилцаа Холбоо Мэдээллийн Технологийн газраас зохион байгуулсан	100

		үйлчилгээ"-ний талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2013 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 153 дугаар тогтоол, ""Төрийн үйлчилгээний нэгдсэн төв"-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2016 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 141 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.		"Үйлчилгээний нэгдсэн төв"-өөр дамжуулан иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх "Төрийн үйлчилгээг операторын тогтолцоонд шилжүүлэх, систем нэвтрүүлэх" сургалтанд ЗДТГ-ын Архив, бичиг хэргийн ажилтанг хамруулсан.	
ЗГ-ын албан даалгавар					
51		1.4. Төрийн үйлчилгээний шимтгэл, төлбөрийн хэмжээг бууруулах.	ТЗУХ /төлбөр хураамжаа бууруулсан бүх сум,газар, агентлагууд/	Татварын үйлчилгээ цахим болсонтой холбоотойгоор иргэд байгаа газраасаа татвараа цахимаар төлснөөр иргэдийн ирж очих зардал багасч үйлчилгээний төлбөр буурсан. 2020 оны 01 сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэн Хувь хүний орлогын албан татварын тухайд хөгжлийн бэрхшээлтэй бүх иргэнийг тухайн төрлийн татвараас чөлөөлсөн, хоол унааны мөнгөнд албан татвар ногдуулдаг байсан бол одоо хоол унааны мөнгө хөдөлмөр эрхлэлтийн орологод тооцогдож НДШ хассан дүнд албан татвар ногдуулахаар болсон байна. Мөн бүх улс оронд төлсөн албан татварыг албан татвар төлөгчийн тухайн татварын жилд төлбөл зохих албан татвараас хасаж тооцох болсон байна.	70
ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ					85%

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР